



МОСК TRIAL-2025 ШҮҮХИЙН МЭТГЭЛЦЭЭНИЙ ДҮРЭМ /ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХИЙН МЭТГЭЛЦЭЭН/

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрэм нь хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудын хооронд “Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хуралдааны мэтгэлцээний тэмцээн” зохион явуулах ажиллагааг зохицуулна.

Хоёр. Эрүүгийн хэргийн шүүхийн мэтгэлцээнийг зохицуулах журам

2.1. Эрүүгийн хэргийн шүүхийн мэтгэлцээнийг зохицуулах журам нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон энэ дүрмээс бүрдэнэ.

Гурав. Нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ дүрэмд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

3.1.1. “зохион байгуулагч” гэж Монголын Хуульчдын холбоог;

3.1.2. “мэтгэлцээн” гэж тэмцээний шүүх бүрэлдэхүүний өмнө шүүгдэгчийн өмгөөлөгч, улсын яллагч багуудын хооронд явагдах ‘зохиомжит шүүх хуралдааны’ үйл ажиллагааг;

3.1.3. “эрүүгийн хэргийн шүүхийн мэтгэлцээн” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид ЭХХШтХ гэх/-д заасан журмын дагуу шүүхийн өмнө мэтгэлцэх тэмцээнийг;

3.1.4. “мэтгэлцээний баг” гэж дүрэмд заасны дагуу шүүхийн мэтгэлцээнд оролцох саналаа ирүүлж, зохион байгуулагчид бүртгүүлсэн хуулийн сургуулийн оюутнуудын нэгдлийг

3.1.5. “яллах тал”, “өмгөөлөх тал”, гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хэргийн оролцогчдыг хэлнэ. Тэдгээрийн эрх, үүрэг мөн хуулиар зохицуулагдана.

3.1.6. “мэтгэлцээний албан ёсны хөтөлбөр” гэж техникийн зөвлөгөөн дээр танилцуулсан мэтгэлцээний дараалал, цаг хугацаа, зохион байгуулалтын талаарх мэдээллийг агуулсан баримт бичгийг;

3.1.7. “мандат” гэж мэтгэлцээний баг тус бүрийг мэтгэлцээний тэмцээнд оролцох эрхтэйг гэрчилсэн баримт бичгийг.

Дөрөв. Тэмцээний зохион байгуулалт

4.1. Тэмцээнийг Монголын Хуульчдын холбооноос энэ дүрмийн дагуу зохион байгуулж явуулна.

4.2. Тэмцээний зохион байгуулалтад зарцуулагдах нийт төсвийг Монголын Хуульчдын холбоо болон мэтгэлцээний багууд бүрдүүлнэ.

4.3. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хуралдааны мэтгэлцээн явагдах хавтаст хэргийг зохион байгуулагч нууцлал өндөртэйгээр сонгож, битүүмжилнэ. Зохион байгуулагч нь хавтаст хэргийн нууцлалын баталгаа гаргана.

4.4. Зохион байгуулагч техникийн зөвлөгөөнийг нэг удаа зохион байгуулна.

4.4.1. Техникийн зөвлөгөөн нь хууль зүйн сургуулиуд мэтгэлцээнд оролцох тухайгаа мэдэгдсэний дараа явагдана. Тус зөвлөгөөнөөр мэтгэлцээний батлагдсан дүрмийг танилцуулах ба битүүмжилсэн кейсийг задална.

Тав. Мэтгэлцээн

5.1. Мэтгэлцээнд оролцож байгаа баг бүр өгөгдсөн хэргийн хүрээнд улсын яллагчийн болон өмгөөллийн үг тус бүрийг урьдчилан боловсруулж бэлтгэсэн байх шаардлагатай.

5.2. Мэтгэлцээн хавтаст хэрэгт авагдсан нотлох баримт болон шүүхийн хэлэлцүүлэгт тулгуурлан явагдана.

Зургаа. Тодруулга

6.1. Багууд зохион байгуулагчид мэтгэлцээний асуудлаар тодруулга гаргаж өгөх хүсэлтийг бичгээр тавьж болно. Зохион байгуулагч нь хүлээн авсан хүсэлтүүдэд үндэслэн асуудлуудад нийтэд тодруулга өгнө.

Долоо. Мэтгэлцээнд оролцох баг

7.1. Хууль зүйн сургууль тус бүр шалгарсан нэг баг бэлтгэж оролцуулна.

7.2. Баг нь зургаа хүртэлх гишүүнээс бүрдэнэ. Эдгээрээс шүүхийн мэтгэлцээний тоглолт тус бүрт багийн гурван гишүүн мэтгэлцэнэ. Мэтгэлцээнд оролцох гишүүд нь мэтгэлцээний явцад солигдож үл болно.

7.3. Багийн гишүүнд дараах шаардлага тавигдана.

7.3.1. Хууль зүйн дээд боловсрол олгох тусгай зөвшөөрөл бүхий сургуулийн бакалаврын боловсролын зэрэг горилох, үндсэн ангийн сургалтад хамрагдаж байх;

7.3.2. Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн хичээлд хамрагдаж, амжилттай судалсан байх;

Найм . Шүүгчид

8.1. Шүүхийн тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэргийн шүүхийн шүүгчээр томилогдсон хуульчид тэмцээний шүүгчээр ажиллана.

Ес . Шүүхийн мэтгэлцээн явуулах журам

9.1. Шүүхийн мэтгэлцээн нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон энэ дүрэмд заасан журмын дагуу явагдана.

9.2. Шүүхийн мэтгэлцээнийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэнэ.

9.2.1. Нэгдүгээр шатны шүүхийн мэтгэлцээнийг шүүгч дангаар, дараагийн шатны шүүхийн мэтгэлцээнийг шүүгч бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэж болно.

9.3. Тэмцээн эхлэхийн өмнө аль баг “өмгөөлөх тал”, “яллах тал” болж оролцохыг сугалаа явуулж тогтооно.

Арав. Шүүхийн мэтгэлцээн явуулах хугацаа

10.1. Шүүхийн мэтгэлцээн тус бүр нь нийт 60 минут үргэлжилнэ.

10.1.1. Баг бүрийн яллах болон өмгөөллийн эхний үгийн үргэлжлэх хугацаа нь тус бүр 9 хүртэл минут байна.

10.1.2. Нотлох баримт шинжлэн судлах хугацаа баг тус бүр 7 минут хүртэл үргэлжилнэ.

10.1.3. Асуулт, хариултын хугацаа баг тус бүр 7 минут хүртэл үргэлжилнэ.

10.1.4. Дүгнэлт, шүүмжлэлийн үеийн хугацаа баг тус бүр 10 минут хүртэл үргэлжилнэ.

10.2. Шүүгч, шүүх бүрэлдэхүүн нь талуудын саналыг үндэслэн мэтгэлцээнийг 8 хүртэл минутаар сунгаж болно.

Арван нэг. Шүүх шийдвэр гаргах

11.1. Тэмцээний шүүх бүрэлдэхүүн шийдвэр гаргахдаа дор дурьдсан шалгуурыг баримтлах бөгөөд шалгуур бүрт 1-5 оноогоор дүгнэж, нийт онооны нийлбэрийг үндэслэн шийдвэр гаргана.

- 11.1.1. Тайлбарлаж буй үйл баримтын үндэслэл;
- 11.1.2. Хууль хэрэглээ;
- 11.1.3. Онолын мэдлэг;
- 11.1.4. Асуулт тавьж буй байдал;
- 11.1.5. Асуултад хариулт өгч буй байдал;
- 11.1.6. Няцаах тайлбар гаргаж буй байдал;
- 11.1.7. Нотлох баримтыг үнэлж, ашиглаж буй байдал;
- 11.1.8. Илтгэгчийн ур чадвар;
- 11.1.9. Багаар ажиллах чадвар;
- 11.1.10. Цагийг үр дүнтэй ашигласан эсэх;
- 11.1.11. Мэтгэлцээний соёл.
- 11.1.12. Хуульчийн бичиг баримт боловсруулах ур чадвар.
- 11.2. Энэ дүрмийн 11.1-д заасан шүүгчийн шийдвэрт гомдол гаргахгүй.
- 11.3. Тэмцээний зохион байгуулалттай холбоотой гомдлыг шүүхийн мэтгэлцээн зохион байгуулах 2018 оны ажлын хэсэгт гаргана. Ажлын хэсэг гомдлыг 2 хоногийн дотор хянан үзээд хариу өгнө.

Арван хоёр. Дүрэмд өөрчлөлт оруулах

- 12.1. Тэмцээнийг жил бүр зохион байгуулахад багуудын саналыг харгалзан дүрэмд өөрчлөлт оруулж болно.

Арван гурав. Дүрэм хүчин төгөлдөр болох

- 13.1. Багууд мэтгэлцээний дүрэмтэй танилцаж дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналаа 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор бичгээр болон tsegii.mglbar@gmail.com цахим шуудангаар ирүүлнэ.
- 13.2. Багуудын ирүүлсэн саналыг Хуульчдын холбооноос байгуулагдсан ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж баталснаар энэ дүрэм хүчин төгөлдөр болж, дагаж мөрдөнө.

-----oOo-----